



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 31 өдөр

Дугаар А/131

Арвайхээр

Зардал хуваарилах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 "б", Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны "Эрх шилжүүлэх тухай" 01 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын IV.3.19 дугаартай батлагдсан Төрийн албан хаагчдын албан хэрэгцээний компьютер, тоног төхөөрөмж, автомашин (Өвөрхангай, Бат-Өлзий, Хархорин, Хужирт, Уянга, Зүүнбаян-Улаан сум)-д зарцуулах 300.000.000 (гурван зуун сая) төгрөгний төсөл, арга хэмжээний зардлыг хавсралтаар баталсугай.

2. Хавсралтад тусгагдсан хөтөлбөр арга хэмжээг худалдан авах ажиллагааны дагуу зохион байгуулахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар (Н.Ганболд)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100289

Аймгийн Засаг даргын 2020 оны 03
дугаар сарын 30-ны өдрийн 1134 дугаар
захирамжийн хавсралт

Төрийн албан хаагчдын албан хэрэгцээний компьютер, тоног төхөөрөмж,
автомашин /Өвөрхангай, Бат-өлзий, Хархорин, Хужирт, Уянга, Зүүнбаян-Улаан
сум/- зардлын хуваарилалт

№	Төсөл хөтөлбөр, арга хэмжээний нэр	Тоо ширхэг	Төсөвт өртөг /мян төг/
1	Төрийн байгууллагуудын дунд үйлчлэх бага оврын автобус /Starix/	8	160.000.0
2	Төрийн байгууллагын албан хэрэгцээнд суудлын автомашин /Хархорин сум/	1	12.000.0
3	Хог тээврийн автомашин /Зүүнбаян-Улаан сум/	1	28.000.0
4	Засаг даргын Тамгын газар суудлын автомашин /Зүүнбаян-Улаан сум/	1	50.000.0
5	Бат-Өлзий сумын Засаг даргын Тамгын газар болон багуудын төвд хурлын сандал	400	35.000.0
6	Төрийн албан хаагчдын албан хэрэгцээнд компьютер, тоног төхөөрөмж	-	15.000.0
	НИЙТ ДҮН		300.000.0

-oOo-